



Орон нутгийн хамтын ажиллагааны
гэрээнд байгаль орчны асуудлыг
тусгах, гэрээ байгуулах талаар
чадавх бэхжүүлэх нь

МЕРИТ төслийн төлөвлөгөөт ажил №17479-МОН, №17480-МОН

Хүлээн авсан: МЕРИТ төсөл

Боловсруулсан: Росс Эклэс

2018 оны 5 дугаар сар



Оршил	2
Ажлын цар хүрээ.....	2
Аргазүй.....	3
Судалгааны үр дүн.....	4
Олборлох салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг зохицуулахад дагаж мөрдөх байгаль орчны холбогдолтой хууль тогтоомж	4
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ.....	8
Байгаль орчны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	10
Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ.....	10
Улаанбаатар хот болон аймаг, сумдад хийсэн уулзалтаас цуглуулсан мэдээлэл	11
Байгаль орчинд тулгамдаж буй гол асуудал	12
Байгаль орчныг хамгаалах заалтууд Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгагдсан байдал	13
Шаардлагатай чадавх, сургалтын хэрэгцээ.....	13
Уурхайн талбай дээр хийсэн ажиглалтын үр дүн	14
Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд байгаль орчны асуудлыг тусгах, гэрээ байгуулах талаар чадавх бэхжүүлэхэд өгөх санал зөвлөмжүүд	19
Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээн дэх байгаль орчны заалтууд.....	19
Байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах	21
Зам ашиглалтын менежмент	21
Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг боловсруулсан ажлын хэсэгт оролцсон хүмүүс.....	24
Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналт, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ... 25	
Чадавх бэхжүүлэх, сургалт явуулах хэрэгцээ	26
Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх.....	27
Хорт болон аюултай бодисын удирдлага болон аюултай хог хаягдлыг устгах арга хувилбар	28
Төслийн амьдралын мөчлөгийн үе шат болон байгаль орчны нөлөөллийн хосолсон сургалт	28
Нэгдүгээр хэсэг: Олборлох салбарын төслийн амьдралын мөчлөгийн үе шатууд	28
Хоёрдугаар хэсэг: Төслийн үзүүлэх нөлөөлөл болон нөлөөлөл бууруулах гол арга	29
Хоёрдогч чадавх хөгжүүлэх	29
Газрын доорх усны нөөцийн үнэлгээ, хяналтын систем.....	29
Агаарын чанарын хяналт.....	31
Лабораторийн хүрэлцээ	31
Номзүй.....	32



Оршил

Энэхүү тайлан МЕРИТ төслийн дараах хоёр төлөвлөгөөт ажлын зөвлөмж, үр дүнг агуулсан.

- 17479-MON
- 17480-MON

Хоёр төлөвлөгөөт ажлын зорилтот үр дүн нь:

- Түүхий эд олборлох үйл ажиллагааны (тухайлбал, ашигт малтмал болон газрын тос олборлох) байгаль орчны менежментийн асуудлаар аймаг, сумын төлөөлөгчдийн чадавхыг бүрдүүлж, мэдээлэл өгч сурталчлах;
- Ашигт малтмал, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудтай байгуулах “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-нд байгаль орчныг хамгаалах санаачлагыг тусгахад дэмжлэг болохуйц мэдлэгийн бүтээгдэхүүн, гол гол сэдвийг боловсруулан гаргах; ба
- МЕРИТ төслийн ашигт малтмал, газрын тос олборлох үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй ажилд бодлогын зөвлөмж чиглэл өгөхөд оршиж байв.

Ажлын цар хүрээ

МЕРИТ төслөөс гарган өгсөн *Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай* хуулийн англи хэл дээрх орчуулгаас бусдаар энэхүү тайланд орсон бүх мэдээлэл үндсэндээ МЕРИТ төслийн мэргэжилтэн Б.Наран-Ундрах, түүнчлэн зарим асуудал дээр Э.Амгалангийн хийсэн орчуулгад тулгуурласан. Монголд хийсэн бүх уулзалтын үеэр миний асуултуудыг Б.Наран-Ундрах монгол хэлнээ хөрвүүлэн ярилцагч талд хүргэж, дараа нь тэрээр тэдний хариултыг мөн англи хэлнээ хөрвүүлж надад хэлснээр би уулзалтын тэмдэглэл хөтлөн авах боломжтой байсан. НАС сервер дээр байгаа бүх уулзалтын эцсийн тэмдэглэлийг Б.Наран-Ундрах хянан үзэж, зарим нэг шаардлагатай багахан өөрчлөлтүүдийг хийсэн болно. Эцсийн тайланг Б. Наран-Ундрах, Р.Эрдэнэчимэг нар хянасан билээ.

Энэхүү томилолтын хугацаа гурван долоо хоног байсан тул уулзалтын тэмдэглэлүүдийг Монгол хэлнээ хөрвүүлж, уулзалтанд оролцогчид руу эргүүлэн илгээж, тэднээр хянуулан, орчуулгын явцад ойлголтын зөрүү, алдаа гарсан эсэхийг нягтлах боломж гараагүй. Тиймээс Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгаль орчин хамгаалах талаас нь сайжруулах, судалгаанд хамрагдсан Дорнод, Төв аймаг болон сумдын захиргааны байгууллагын байгаль орчныг хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай сургалт, тэдэнд бүрдүүлвэл зохих чадавхыг ойлгоход чиглэл өгөх зөвлөмж байдлаар уг бичиг баримтыг ашиглавал зохино.



Судалгааны аргазүй

Ажлын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд дараах ажлуудыг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Олборлох салбарт байгаль орчныг хамгаалах чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмыг судлан үзсэн.
- Дараах зорилгоор аймаг, сумдын захиргааны байгууллагын төлөөллүүдтэй уулзаж ярилцсан. Үүнд:
 - Олборлох салбараас үүдэлтэй байгаль орчинд үзүүлж буй гол нөлөөллийн талаар тэдний санааг зовоож буй зүйлсийг ойлгож, тодруулах
 - Уул уурхайн эсвэл газрын тосны компани болон аймаг, сумын захиргааны байгууллага хооронд байгуулж буй “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-ний үүрэг, ач холбогдол, мөн тус гэрээнд байгаль орчныг хамгаалах чиглэлийн арга хэмжээний талаар тусгах хэрэгцээ шаардлагын талаар тэдний үзэл бодол, байр суурийг сонсох
 - Сумын захиргааны байгууллагын байгаль орчноо хамгаалах, түүнд хяналт тавихад нь тустай чадавхыг бүрдүүлэх, үүний тулд ямар сургалт шаардлагатай байгаа талаар тэдний бодлыг таних байв.
- Компаниуд ашигт малтмал, газрын тос олборлох үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн талбайгаар зочилж, тэдгээрийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл болон баримталж буй хамгаалах стратегийг нүдээр үзэж танилцсан.



Судалгааны үр дүн

Олборлох салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг зохицуулахад дагаж мөрдөх байгаль орчны холбогдолтой хууль тогтоомж

Энэхүү томилолтын ажлыг гүйцэтгэхийн тулд хянан үзсэн байгаль орчны холбогдолтой гол хууль тогтоомж нь Монгол Улсын *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль*, түүнийг дагалдан гарсан олон журам, тушаал байлаа. Мөн Засгийн газар болон аймаг, сумын захиргааны байгууллагаас саяхан батлан гаргасан Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хоёр загварыг хянан үзсэн болно.

Практикт байгаль орчныг хэрхэн хянаж буй байдлыг шүүмжлэх нь томилолтын зорилго байгаагүй. Мөн агуулга, нарийн ширийнийг нь үзэж болохуйц тус хуулийн дагуу бодитоор хийсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний орчуулга олдоогүй билээ. Харин томилолтын ажлын хүрээнд олборлох салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, удирдахад баримтлах зохистой бодлого, журам байгаа эсэх, төсөл бүрийн онцлогт тохируулан байгаль орчныг хамгаалах үүднээс уг мэдээллийг Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгаж болох эсэхэд голлон анхаарсан.

Монгол улсад мөрдөгдөж буй олборлох салбартай холбоотой байгаль орчны нөлөөллийг удирдах гол арга хэмжээ, хүлээх хариуцлагыг тоймлон Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1 – Олборлох салбарыг зохицуулж буй байгаль орчны холбогдолтой хуулийн дагуу хүлээх хариуцлага

МЕРИТ төсөлд зориулан бэлтгэв

Төлөвлөгөөт ажил №17479, 17480

Хуулийн шаардлага	Хариуцагч тал	Тайлбар
Суурь үнэлгээ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч төлбөрийг төлдөг ч эрх бүхий үнэлгээний компани гүйцэтгэдэг.	Хайгуул эсвэл бүтээн байгуулалтын ажил эхлэхээс өмнө гүйцэтгэсэн байх ёстой.
Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ	БОАЖЯ 14 хоногт багтаан хийх ба тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ямар нэгэн зардал гарахгүй.	Дараах дүгнэлтийг гаргадаг өндөр түвшний байгаль орчны хяналтын баримт бичиг юм. Үүнд: <ul style="list-style-type: none">• Төсөл хэрэгжүүлэхээс татгалзах эсвэл буцаавал зохино.• Төсөл байгаль орчинд бага нөлөө үзүүлэх тул төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж болно.• БОАЖЯ-наас өгсөн зөвлөмжүүдийг тусган өөрчилснөөр төслийг цаашид хэрэгжүүлэх боломжтой.• Тухайн төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай.

		БОАЖЯ байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг таван жил тутамд шинэчилж байхыг шаарддаг.
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч төлбөрийг хариуцдаг ч эрх бүхий үнэлгээний компани, аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь дараах үүрэг бүхий төлөвлөлтийн үндсэн арга хэрэгсэл юм. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Тодорхой нэг төслийн эрсдэл, сөрөг нөлөөллийг тооцоолох, үнэлэх; • Эрсдэл, сөрөг нөлөөллийг бууруулах үндсэн арга хэмжээг тодорхойлох; • Эхний жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг урьдчилсан байдлаар гаргаж ирдэг байна. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг БОАЖЯ баталж, хянадаг.
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Тусгай зөвшөөрөл эзэмшигч төлбөрийг хариуцдаг ч эрх бүхий үнэлгээний компани бэлтгэнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дээрх үнэлгээгээр олж тогтоосон байгаль орчны эрсдэлийг бууруулж, хянахын тулд “ <i>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ</i> ”-ний стратегийн зорилтуудыг бодитой, төсөвтэй, цаг хугацаатай үйл хэрэг болгон буулгадаг. <p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах зүйлсээс бүрддэг:</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө • Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр Тухайн жилд тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны чиглэлээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлснийг тодорхой харуулах зорилгоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр шинэчлэх ёстой. <p>Засаг дарга тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянах эрхтэй. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар эхний болон удаах жилүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталдаг.</p>
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан	Тусгай зөвшөөрөл эзэмшигч бэлтгэж, холбогдох зардлыг хариуцна.	Энэ нь байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилтуудын биелэлтийг харуулах зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигч жил бүр бэлтгэдэг тайлан юм.
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэнэ.	Ажлын хэсэг аливаа тусгай зөвшөөрөл эзэмшигч Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлснийг жил бүрийн эцэст дүгнэдэг. Ингэхдээ Сайдын тушаалаар баталсан гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд тулгуурлан үнэлж дүгнэдэг. Уг ажлын хэсэг нь ихэвчлэн аймгийн харьяалах газар, сумын захиргааны байгууллага болон

		<p>нөлөөллийн бүс дэх иргэдийн төлөөллөөс бүрддэг.</p> <p>Ажлын хэсэг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүлээж авсны дараа буюу жилийн эцэс болохоос өмнө дүгнэлтээ гарган Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлдэг. Дараагийн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхээс өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жил байгаль орчны чиглэлээр хүлээсэн үүргээ наад захын шаардлагатай түвшинд биелүүлсэн гэдгээ нотлон харуулах ёстой.</p>
<p>Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ</p>	<p>Одоогийн байдлаар уул уурхайн компаниудтай байгуулчхаад байгаа Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг зөвшилцөх, байгуулах ажлыг сумын Засаг дарга голчлон хариуцаж байна.</p> <p>Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний загвар нэгэнт эцсийн байдлаар бэлэн болсон учраас гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох оролцогчдын тоог нэмэгдүүлэх нь зүйтэй.</p>	<p>Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Монгол Улсын харгалзах засаг захиргааны нэгжийн Засаг дарга хоорондын Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний зорилго бол “компанийн зүгээс аймаг, сумын захиргааны байгууллага болон цаашлаад аймаг, сумын ард иргэдийн амьдралд оруулах хувь нэмрийг албажуулах явдал” юм (Ingen-housz, 2017 (a)).</p> <p>Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг баталж, хянаж, хэрэгжүүлэхэд дараах талуудыг оролцуулбал хамгийн тохиромжтой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сумын Засаг дарга • Сумын захиргааны байгууллагын төлөөлөл • Аймгийн хэрэгжүүлэгч агентлагийн төлөөлөл (жишээлбэл, Мэргэжлийн хяналтын газар) • Сумын ард иргэдийн төлөөлөл • ТББ-ын төлөөлөл (боломжтой бол, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга) • Уул уурхайн компанийн төлөөлөл. <p>Гэрээний практик одоо ч хөгжсөөр байна.</p> <p>Дорнод аймгийн Засаг дарга аймгийн Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний загвар боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр ажлын хэсэг байгуулсан бөгөөд тус ажлын хэсэгт Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын төлөөлөл, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч нар багтсан. Сумд нь дээрх загвар гэрээнд тулгуурлан төсөл бүрийн онцлогт тохирох Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг боловсруулан байгуулж байх шаардлагатай болсон.</p>

<p>Хууль болон дагаж эрхзүйн актын хяналт тавих</p> <p>тогтоомж нийтээр мөрдөх бусад биелэлтэд хяналт тавих</p>	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-аас гүйцэтгэдэг. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ямар нэгэн зардал гардаггүй.</p> <p>МХЕГ нь БОАЖЯ-наас тусдаа, бие даасан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.</p>	<ul style="list-style-type: none"> • МХЕГ-ын эрхлэх асуудал нь Монголын байгаль орчны хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, тэр дундаа байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүрэг хариуцлагын биелэлтийг хянан шалгах явдал билээ. • Төслийн түвшинд ихэнх хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хянах үүрэг хариуцлагыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагчид хүлээдэг. • Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь хүн хүч болоод тоног төхөөрөмжийн хувьд бололцоо багатай байдаг. • Мэргэжлийн хяналтын газрын байцаагчид хууль биелүүлэхгүй байгаа тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох хүртэл эрхтэй.
<p>Талбай дээр хийх хяналт шалгалт</p>	<p>МХЕГ-ын байцаагч, сумын байгаль хамгаалагч үүнд хяналт тавьдаг. Байгаль хамгаалагч нар БОАЖЯ-ны харьяанд байдаг бөгөөд МХЕГ-аас хамааралгүй бие даан ажилладаг.</p>	<ul style="list-style-type: none"> • МХЕГ-ын байцаагч нар эрүүл ахуй, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин зэрэгт өргөн хүрээний хяналт тавьдаг. • Одоогийн байдлаар байгаль хамгаалагчийн хяналтын үйл ажиллагаанд ундны усны чанар гэх мэт ус, хөрсний бохирдлыг талбай дээр нь барагцаалан хянаж, багахан хэмжээнд лабораторийн шинжилгээ хийх зэргээр хязгаарлагдаж байна. Мөн элэгдэл, цөлжилт зэрэг хөрсний зүй бус эвдрэлд байнга ажиглалт хийх үүрэгтэй.
<p>Нийцлийн аудит</p>	<p>Эрх бүхий хувийн компаниуд гүйцэтгэдэг бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч зардлыг хариуцна. БОАЖЯ, СЕСМИМ (Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх төсөл) хамтран байгаль орчны аудитын сургалт явуулж, хамрагдсан хүмүүст гэрчилгээ олгожээ.</p>	<p>Дараах тохиолдолд заавал аудит хийхийг шаарддаг байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • БОАЖЯ-аас гаргасан ажлын даалгаварт үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний бүрэн гүйцэт эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай болох • Жил бүрийн байгаль орны менежментийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж байгаа эсэхэд хоёр жилд нэг удаа төлөвлөгөөт аудит хийдэг. • Байгаль орчны зорилтын үзүүлэлтүүдээ баримталж байгаа байдал (Жишээ нь: усны чанарын зорилт. Энд аудитын баг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас өгсөн талбайн хэмжилтийн мэдээлэлд тулгуурлаж болох юм).



Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

Монгол Улсын байгаль орчинд нөлөөллөх байдлын үнэлгээний эрхзүйн орчин нь ашигт малтмал, газрын тос олборлолтын бүхий л үйл ажиллагааг хамарсан харьцангуй цогц, ойлгомжтой зохицуулалттай юм. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийг анх Азийн хөгжлийн банкны техникийн тусламжтайгаараа 1993-1994 онд боловсруулан гаргаж байв. Түүнээс хойш, уг хуульд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт хийж явсаар, хуулийн шинэчилсэн найруулга 2012 оны 5 дугаар сард батлагдсан (Эх сурвалж: Р.Эрдэнэчимэгийн байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийн тойм).

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд тус хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор таван журам боловсруулж, Засгийн газраар батлуулах буюу өөрөө баталсан. Үүнд:

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
- Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам багтана.

Түүнчлэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журамд заасан үүргээ биелүүлэхгүй байгаа бодит байдлыг шийдвэрлэх үүднээс хуулийн шинэчилсэн найруулгад хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг (тухайлбал, үйл ажиллагааг нь зогсоох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох) оруулсан. Дээр дурдсан журмуудаас сүүлийн хоёр журам, тэдгээрийн заалт нь Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээтэй илүү уялдаатай.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар томоохон хэмжээний олборлох үйл ажиллагаа явуулж буй төслүүдэд БОАЖЯ-наас эрх авсан, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хөлсөлсөн үнэлгээний компани байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэнэ. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ бол тодорхой нэг төслийн эрсдэл, үзүүлэх нөлөөллийг тодорхойлдог төлөвлөлтийн чухал арга хэрэгсэл юм. Үүнд урьдаас тогтоосон эрсдэлийг бууруулж, хянахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний стратегийн зорилтуудыг бодитой, төсөвлөгдсөн, хугацаатай үйл хэрэг болгон буулгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөө багтах ёстой.” (Эх сурвалж: Р.Эрдэнэчимэгийн байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийн тойм). Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дараа жилийн байгаль хамгаалах ажлуудаа тодорхой тусгаж жил бүр шинэчлэн баталж байхыг шаарддаг.

Мөн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төсөл хэрэгжүүлж буй аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх ёстой. Энэхүү тайланд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ хэр биелүүлснийг тайлагнасан байх учиртай. Компани тухайн жилийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт, хортой хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний



биелэлт болоод хараат бус гуравдагч талын хийсэн аудитын тайланг мөн хавсарган өгөх үүрэгтэй.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, дагалдах бичиг баримтуудыг шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар аймаг, сумын Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл, аймаг, сумын Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, нөлөөллийн бүс дэх ард иргэд, ТББ-ын төлөөллийг оролцуулан байгуулна. Тус ажлын хэсэг нь *“Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”*-д заасан үнэлгээний шалгууруудыг баримтална.

Үнэлгээний шалгуурт:

- Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
- Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн хэлэлцүүлэг, түүний тайлагналын биелэлт

Үнэлгээний шалгуур бүрт 1 (хамгийн муу)-ээс 10 (хамгийн сайн) хүртэлх оноог өгдөг. Арван бүрэлдэхүүн хэсэгтэй тул нийт үнэлгээний хамгийн дээд оноо нь 100 байх боломжтой. Хэрэв компанийн үнэлгээний арифметик дундаж нь 80 оноонд хүрэхгүй бол дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахгүй. Түүнчлэн, төслийн хувьд хууль зөрчвөл хүлээлгэх хариуцлагын заалтыг (үйл ажиллагааг зогсоох, ашиглалтын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох) хэрэгжүүлэх үндэслэл болно.

Одоогийн үнэлгээний тогтолцоогоор шалгуур үзүүлэлт болгон авах онооны хувьд тэнцүү хувийн жинтэй (шалгуур бүр нийт үнэлгээний онооны 10%) байна. Ингэснээр байгаль орчны зүй бус практик ажиллагааг тодорхойлох үнэлгээний үр дүнг сулруулдаг. Жишээлбэл, аль нэг компани тухайн жилд нөхөн сэргээлт болон хог, хаягдлын менежментийн чиглэлээр юу ч хийгээгүй атлаа бусад шалгууруудыг нэлээд сайн гүйцэтгэсэн бол арифметик дунджаараа ‘хангалттай’ гэсэн оноо авах боломжтой байгаа юм. Нөхөн сэргээлт болон хог, хаягдлын менежмент бол байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд хамгийн чухал шалгуур үзүүлэлт болохыг анхааралдаа авч, байгаль орчныг хамгаалах ажлыг хангалтгүй хийх боломж олгож байгаа уг хуулийн “цоорхойг” арилгах шаардлагатай байна. Ингэхдээ, нөхөн сэргээлт болон хог, хаягдлын менежментийн биелэлтэд ногдох онооны хувийн жинг нэмэгдүүлэх замаар хялбархан шийдэж болох юм (Жишээлбэл, нөхөн сэргээлт 40%, хог, хаягдлын менежмент 20%, үлдсэн 40%-ийг бусад найман шалгуур үзүүлэлтэд зохих хувийн жингээр оноон өгч болох юм). Энэ нь компаниуд байгаль хамгаалах хамгийн чухал шалгуур үзүүлэлтүүдэд анхаарах явдлыг хуульчилж өгнө. Үр дүнд нь тэдний байгаль хамгаалах ажлын чанар сайжрах юм.



Байгаль орчны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Засгийн газар саяхнаас “экологийн дүйцүүлэн хамгаалах” гэх ойлголтыг ашигт малтмал, газрын тосны олборлолтын үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нэгэн арга хэмээн үзэх болсон. Тиймээс, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэрэгсэл болохынх нь хувьд байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах үүргийг төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгахыш шаарддаг.

Тун саяхнаас БОАЖЯ уул уурхайн компаниудын экологийн нөхөн төлбөр төлөх нэгэн хэлбэр болох дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хэрэглээний талаар журмын төсөл боловсруулж эхэлсэн. Одоогоор уг журмын төслийг Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулах шатанд явж байгаа. Батлагдан гарах хугацаа нь тодорхойгүй байна.

Мөн БОАЖЯ ашигт малтмал, газрын тос олборлох үйл ажиллагаанаас үүдэлтэй экологийн хохирлыг зохих ёсоор барагдуулснаар эвдрэлд орсон талбайд үзүүлэх экологийн үр өгөөжийг дээшлүүлэх үүднээс түүнтэй дүйцэх экологийн баталгааны зардлыг хэмжих, тооцоолох аргачлал боловсруулах тал дээр “Де Нэйче Консерванси” (The Nature Conservancy) байгууллагатай хамтран ажиллаж байна.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ

Агуулгын хувьд олборлох салбарын компани болон аймаг, сумын хооронд байгуулж буй Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний зорилго бол “Компанийн зүгээс аймаг, сумын захиргааны байгууллага болон цаашлаад аймаг, сумын ард иргэдийн амьдралд оруулах хувь нэмрийг албажуулах явдал” юм (Ingen-housz, 2017 (a)). Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ шинэ ойлголт биш юм. 2006 онд батлагдаж, 2014 онд нэмэлт өөрчлөлт орсон Ашигт малтмалын тухай хууль, 2014 оны Газрын тосны тухай хуулийн хэд хэдэн зүйлд Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг ерөнхийдөө төслийн нөлөөлөлд өртөх сумын Засаг даргын санал, дэмжлэгтэйгээр байгуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаарддаг. Тухайлбал, 2014 оны Газрын тосны тухай хуулийн 11.2.17 дугаар зүйлд зааснаар газрын тосны компаниуд “ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах” ёстой гэж заасан байдаг. Үүний адилаар, Ашигт малтмалын тухай хуулийн 42.1 дүгээр зүйлд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана” гэж заасан. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний холбогдолтой хуулийн одоогийн нөхцөл байдлын талаарх шүүмжийг М. Ingen-Housz 2017 (b) өөрийн бүтээлдээ оруулсан.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд ихэвчлэн “байгаль орчныг хамгаалах, орон нутгаас ажиллах хүчин авах, худалдан авалт хийх, дэд бүтцийг хөгжүүлэх талаар хүлээх үүрэг хариуцлагыг” тусгадаг (Д.Бямбажав. 2018 он). Гэсэн ч одоог хүртэл эдгээр гэрээний бүтэц, агуулга нь сум болон төсөл бүрт өөр өөр байгаа нь төрийн захиргааны төв байгууллагууд Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний үндсэн зорилго, зарчмыг нарийн тодорхой болгох шаардлагатайг илтгэж байна. Түүнчлэн, өнөөдрийг хүртэл миний хянан үзсэн Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгасан байгаль орчныг хамгаалахтай холбоотой заалтууд нь талбайн нөхөн сэргээлт, гадаргын болон газрын доорх усны хамгаалалт, мөн зохистой ашиглалт, аюултай хог, хаягдлын менежмент зэрэг гол асуудлуудын хувьд хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан шаардлагаас илүүтэйгээр



угаас дагаж мөрдөх ёстой Монгол Улсын хууль тогтоомжийн зүйл заалтуудыг өргөн хүрээнд эшлэн оруулснаар хязгаарлагдаж байна.

2016 онд Монгол Улсын Засгийн газар “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ”-ний загварыг баталсан. Гэвч уг загвар нь хамрах хүрээний хувьд явцуу төдийгүй байгаль хамгаалах талаар цөөхөн чиглэл удирдамж өгсөн нь нөхцөл байдлыг тодорхой болгохоосоо илүүтэйгээр төөрөгдөлд хүргэж байна (Д.Бямбажав 2018). Гэрээний эдгээр агуулгыг тодорхой болгох зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам одоо Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний загварын шинэчилсэн төсөл дээр талуудын саналыг авч байгаа бөгөөд энэхүү тайланг бэлтгэх үед эцсийн хувилбар нь бэлэн олдоогүй болно.

5 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар Дорнод аймаг саяхан Шинь Шинь ХХК-ийн хүсэлт гаргаад буй өнгөт металл олборлох төсөлд зориулан Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний загварын төслийг боловсруулаад байна. Энэхүү загвар гэрээний Шинь Шинь ХХК-ийн эрх, үүргийн тухай зүйлийн 4.2-т “*Ашиглалтын үйл ажиллагааны явцад орон нутгийн байгаль орчныг хамгаалахын тулд Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө*” хэмээн заасан нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр тусгасан зүйлс нь Монгол Улсын хуулиар хүлээсэн үүрэгт л дахин хязгаарлажээ.

Улаанбаатар хот болон аймаг, сумдад хийсэн уулзалтаас цуглуулсан мэдээлэл

Аймаг, сумын захиргааны байгууллагын дараах төлөөллүүдтэй уулзсан. Үүнд:

- Чойбалсан хотод Дорнод аймгийн Засаг даргын орлогч
- Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Дорнод аймгийн Баяндун сумын Засаг дарга, бусад төлөөлөгч
- Чойбалсан хотод Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Чойбалсан хотод Төрийн бус байгууллагын төлөөлөл н.Гэнцогт
- Дорнод аймгийн Халхгол сумын Засаг дарга, бусад төлөөлөгч
- Чойбалсан хотноо Дорнод аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
- Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Чойбалсан хотод Дорнод аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Улаанбаатар хотод БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн дарга
- СЕСМИМ төслийн Монгол дахь захирал
- Зуунмод хотод Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Зуунмод хотод Төв аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
- Улаанбаатар хотод Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын төлөөлөл багтсан.



Аймаг, сумын түвшинд хийсэн бүх уулзалтын үеэр бид дараах гурван асуултыг тавьсан. Үүнд:

- Олборлох салбартай холбоотойгоор тэдний санааг зовоож буй байгаль орчны тулгамдсан гол асуудал юу байв?
- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд байгаль орчныг хамгаалах чиглэлээр ямар арга хэмжээ тусгахыг хүсч байна вэ?
- Сумын байгаль хамгаалал, менежментийг сайжруулахад нь туслахын тулд ямар чиглэлээр чадавх бүрдүүлэх сургалт явуулах хэрэгтэй байна вэ?

Бүх уулзалтын тэмдэглэлийг МЕРИТ төслийн НАС серверийн Техникийн зөвлөхийн фолдер дотор оруулсан (СЕСМИМ, ОУИТБС-ын төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр тэмдэглэл хөтлөөгүй). Уулзалтын үеэр олон дурдагдсан нийтлэг асуудал, авууштай чухал санааг дараах хэсэгт тоймлон орууллаа.

Байгаль орчинд тулгамдаж буй гол асуудал

МЕРИТ төслөөс хийсэн Дорнод аймгийн олборлох салбарын талаарх өмнөх судалгаанд (M. Ingen-housz 2017 (a)), аймаг, сумын түвшинд дараах байгаль орчны асуудал тулгамдаж байгааг тогтоожээ. Үүнд:

- Тус салбараас үүдэлтэй гадаргын болон газрын доорх усны зохисгүй ашиглалт, бохирдол
- Уурхайн нөхөн сэргээлтийг дутуу хийх
- Химийн болон шатамхай бодисын хадгалалт, ашиглалт, устгал
- Уул уурхайн замбараагүй тээвэрлэлтийн улмаас хөрс эвдрэлд орж, агаарт шороо тоос дэгдэж, цөлжилт явагдах зэрэг багтжээ.

Уулзалт бүр дээр хүмүүс эдгээр асуудлыг бүгдийг нь эсвэл заримыг нь давтан хэлж байлаа. Үүнээс гадна, хөрсний бохирдол, бохирдсон хөрс ба материалыг устгах стандарт дутмаг байгаа, тоосжилтын агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл зэрэг бусад асуудлыг хөндөж байв.

Мөн уулзалтын үеэр хэлэлцсэн зүйлсийн нэлээд хэсэг нь аймаг, сум, Засгийн газрын яамд, олборлогч компаниудын хоорондын харилцаа холбоог өргөжүүлэх тал дээр голлон төвлөрсөн. Үүнтэй холбоотой тулгарч буй асуудал нь:

- Компаниуд тухайн орон нутгийн ард иргэдтэй харилцаа сайтай байх, олон нийтийн хэлэлцүүлэг явуулах тал дээр дутагдалтай байгаагаас ерөнхийдөө сум, ард иргэд олборлох салбарт тэр бүр итгэдэггүй.
- Байгаль орчныг хамгаалах тал дээр аймаг, сумын захиргааны байгууллага, Засгийн газрын яамд хоорондын ажлын уялдаа холбоо, зохицуулалт сул байна. Тодруулбал, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг үнэлсэн ажлын хэсэг компанийн үүргийн биелэлтийг 'хангалтгүй' гэж дүгнэсээр байтал зөрчил гаргасан компанийн үйл ажиллагааг зогсоох, торгууль ногдуулах эрх бүхий аймаг, Засгийн газрын агентлагууд ажлын хэсгийн гарган тавьсан асуудал, дүгнэлт зөвлөмжийг хайхарч үзээгүй олон тохиолдол гарчээ.
- Компаниудаас дагаж мөрдөхийг шаардаж буй нөхөн сэргээлттэй холбоотой журмуудын талаарх мэдлэг, ойлголт дутмаг, хэрэгжилт хангалтгүй байна.



Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд байгаль орчныг хамгаалах заалтыг тусгасан байдал

Өнөөдрийг хүртэл голчлон сумын Засаг дарга болон олборлолт явуулж буй компаниуд л хоорондоо уг гэрээг байгуулсаар ирсэн тул зөвлөхийн уулзсан олон хүн Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулахад оролцоо багатай байжээ. Цаашлаад, Засгийн газрын яам Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний бүтэц, агуулгыг шинэчлэх загварын төсөл дээр ажиллаж эхэлсэн бөгөөд харгалзах талуудын санал, зөвлөмжийг авах үүднээс төрийн байгууллагуудад тараах шатандаа явж байна. Үүнээс болоод, ихэнх уулзалтын оролцогчдын Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд байгаль орчны заалтууд хэр тусгагдсан талаарх үзэл бодол нь дөнгөж бүрэлдэж эхэлж байв. Өөрөөр хэлбэл, аймаг, сумын түвшинд гэрээний тухай үзэл бодол нь зарим нэгэн ялгаатай байв. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний талаарх тэдний гол санааг дор оруулав. Үүнд:

- Уулзалтад оролцогчдын дийлэнх нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль орчныг хамгаалах, хяналт тавих чиглэлээр хүлээх үүргийг тусгах эсвэл батласан байгаль орчин менежментийн төлөвлөгөөг бүхлээр нь Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд оруулах нь илүү үр дүнтэй хэмээн үзжээ.
- Ийм бодолтой хүмүүс байгаль орчны менежментийн төлөвлөгөөг оруулах нь сумын зүгээс компаниудын байгаль орчны чиглэлээр хүлээж буй үүргийг бүрэн ойлгож, тэдний хяналт оролцоо нэмэгдэнэ гэж үзсэн. Ингэснээр, Монголын байгаль орчны салбарын хууль тогтоомжийн дагуу компанийн хүлээх үүрэг хариуцлагын талаарх сумын захиргааны байгууллага, ард иргэдийн мэдлэг, ойлголт нэмэгдэх учраас нэг талаас компанийн хууль тогтоомжийг дагаж мөрдөх байдал, нөгөө талаас төрийн захиргааны байгууллагын байгаль орчны чиглэлийн үүргийн биелэлтэд тавих хяналт сайжрах талтай.
- Гэрээг орон нутгийн иргэдэд илүү ач холбогдолтой болгохын тулд Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг батлах, хэрэгжүүлэх үйл явцад орон нутгийн иргэдийн төлөөллийг татан оролцуулах явдал чухал болохыг хэд хэдэн оролцогч онцолж байв.
- Нэг сумын захиргааны байгууллагын төлөөлөл компанийн жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөт ажлын хугацаа, байршил, тайлбар, төсвийн талаарх үүргийг Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тодорхой зааж өгөх шаардлагатайг онцолсон.

Шаардлагатай чадавх, сургалтын хэрэгцээ

Олон уулзалтын үеэр хүмүүс дараах чиглэлд мэргэжилтнүүдийн чадавхыг бүрдүүлж, сургалтад хамруулах нэн шаардлагатай гэж саналаа хэлж байв. Үүнд:

- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх
- Химийн хорт болон аюултай бодис/материалын хадгалалт, тээвэрлэлт зэргийг багтаасан хорт болон аюултай бодис/материалын удирдлагын тогтолцоо
- Бохирдсон хөрс, өрөмдлөгийн хаягдал зэрэг аюултай хог хаягдлыг булшлах, устгах тогтолцоо зэрэг орж байна.

Сургалт явуулах шаардлагатай гэж арай цөөн давтагдсан дараах сэдвүүд байв. Үүнд:

- Гадаргын болон газрын доорх усны хамгаалалт, хяналтын тогтолцоо



- Орон нутгийн агаарын чанарын хяналт, ялангуяа ард иргэдийн амьдарч буй газрын ойролцоох агаар дахь тоосжилт
- Тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих
- Сумын түвшинд сайн ойлголтгүй байгаа сэдэв болох байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянах, тайлагнах үйл явц
- Газрын тосны орд ашиглах, ашигт малтмал олборлох төслийн амьдралын мөчлөг буюу үе шатууд. Үүний зорилго нь сумын захиргааны байгууллага, ард иргэдэд олборлох салбарын үйл ажиллагааны талаар суурь мэдлэг, тус салбарын хууль тогтоомжийн дагуу компанийн хүлээх үүргийн талаарх ойлголтыг өгөхөд оршино.

Аймгийн нэг төлөөлөл ашигт малтмал, газрын тосны чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийн дийлэнх нь Улаанбаатар хот дахь Засгийн газрын яамд, агентлагт голлон ажилладаг болохыг дурдсан. Тэрээр аймгийн түвшинд олборлох салбарыг удирдан зохицуулах ажлыг үр дүнтэй явуулахын тулд орон нутгийн мэргэжилтнүүдэд ашигт малтмал, газрын тосны чиглэлээр нарийн мэдлэг олгож, мэргэшүүлэх хэрэгтэй гэж боддогоо хэлсэн. Улаанбаатар хотод хийсэн уулзалтын үеэр өөр нэг төрийн байгууллагын төлөөлөл өгүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах үүрэгтэй ажлын хэсгийн гишүүд компанийн байгаль орчны чиглэлээр хүлээсэн үүргийн биелэлтийг үнэлэх ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд нь ашигт малтмал, газрын тосны үйлдвэрлэл, байгаль орчны үнэлгээний чиглэлийн туршлага дутмаг байж болзошгүй гэж санаа зовниж явдаг, тийм учраас ашигт малтмал, газрын тос олборлолтын төслийн амьдралын мөчлөгийн үе шатууд, төслийн тухайн шат бүрт холбогдох байгаль орчны нөлөөллийн талаарх хоёр сэдвийг хамтатган хосолсон сургалт явуулбал өгөөжтэй байх болов уу хэмээж байв.

Уурхайн талбай дээр хийсэн ажиглалтын үр дүн

Дараах дөрвөн байршилд хүрэлцэн очиж, ажиглалтын аргаар судалгаа хийсэн.

- **Гүн-Өндөр булаг шороон орд.** Энэ бол тус хөндийд гар аргаар шороон ордны алт олборлож байгаад нөхөн сэргээлт хийлгүй орхисон газар байв. Өөрөөр хэлбэл, бичил уурхай буюу хамрах талбай нь 20 га газраас бага тул Засаг даргаас зөвшөөрөл авах ёстой гэсэн үг. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан мөрдөж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авахыг шаарддаггүй. Эл эвдэрсэн газарт алтны судал бүхий голын хайргыг гарган авахын тулд ухсан 8-10 метр гүнтэй олон нүх, газар ухсанаас үүсэн шороон овоолго олноороо байсан бөгөөд өнгөн хэсгийн хөрсийг нөхөн сэргээлтэд ашиглах зорилгоор зохистой хадгалсан гэх зүйл ажиглагдаагүй. Аз болж овоолгын материал нь зарим нэгэн органик агууламжтай, нүдэнд ил харагдах бохирдолгүй, харьцангуй сайн бүтэцтэй шороо хайрганаас бүрдэж байна. Энэ талбайд хэзээ нэгэн цагт нөхөн сэргээлт хийхээр шийдвэл тухайн ажил их энгийн бөгөөд амжилттай явагдахаар байна.



Баяндун сумын хойд зүгт байрлах шороон ордын хаягдсан бичил уурхай

- **Жамп шороон ордын алтны уурхай.** Одоо олборлолт явуулж буй харьцангуй том шороон ордын ил уурхай юм. Уг уурхайн хувьд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж, жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө батлуулахаар хүргүүлэх үүрэгтэй бөгөөд би эдгээр бичиг баримтыг нь үзэхийг хүссэн ч олдоогүй. Бид овоолгыг тэгшилж, нөхөн сэргээлт хийсэн гэх уурхайн нэг хэсэг газарт очиж ажигласан бөгөөд өнгөн хэсэг нь барзгар чулуурхаг хөрстэй, ургамлан нөмрөг байгаа шинж маш бага байлаа. Нөхөн сэргээлтэд ашиглахын тулд талбайн өнгөн хөрсийг зохистой хадгалах оролдлого хийсэн эсэх нь тодорхойгүй. Алтны судал бүхий хайрга руу хүрэхийн тулд ухсан нүхийг буцаан битүүлээгүй байсан бөгөөд газрын доорх ус нэвчиж нүхийг дүүргэжээ. Уг усан санг энэ чигээр нь үлдээн, усны эхийг загасны амьдрах орчин болгож, загас нутагшуулах талаар ярьж байгаа.



Баяндун сумын хойд зүгт байрлах шороон орд ашиглаж буй уурхайн нөхөн сэргээлт хийсэн хэсэг

- **Петрочайна XXI талбай.** Халхгол сумаас баруун зүгт 150км орчим зайд байрлах газрын тос олборлож буй томоохон цогцолбор бөгөөд захиргааны төв байр, ажилчдын амрах байр, газрын тос нөөцлөх, шилжүүлэн ачих байгууламжаас бүрддэг. Цогцолборын эргэн тойронд олон цооног бүхий олборлолтын талбай тархан байрласан. Газрын тосыг хүнд даацын автомашинаар зүүн хойд тээврийн коридорын дагуу Хятад руу тээвэрлэдэг ба тухайн тээврийн замын зүүн хэсгийг нь Петрочайна хатуу хучилт хийсэн. Зөвлөх 5 дугаар сарын 8-ны өдөр талбай дээр хийсэн ажиглалтын үр дүнд гарсан байгаль орчныг хамгаалах үүргийн биелэлтийн тайланг НАС сервер дээрх техникийн зөвлөхийн фолдерт хийсэн. Ажиглалтаар биелэлт хангалтгүй байгаа гол гол асуудал нь ирээдүйд нөхөн сэргээлтэд ашиглах зорилгоор өнгөн хөрсийг төв цогцолбор болон цооногийн ойр тойрны талбайд зохистой хадгалаагүй, байгууллагын хатуу хог хаягдлын менежмент болон ил хог хаях практик муу байна. Үүнээс гадна, өрмийн шингэн хаягдлыг соруулан авч, хүнд даацын автомашинд ачиж, батлагдсан хог хаях төвлөрсөн байгууламжид аваачин хаяхын оронд эгнүүлсэн хаягдлын сан ухаж, түүндээ шууд хийн малтлагын сул шороогоор булж, дээрээс нь нимгэн өнгөн хөрсөөр хучсан байна. Эдгээр хортой бодис ирээдүйд ямар нөлөө үзүүлэхийг сайн ойлгохгүй (жишээлбэл, газрын хөрсөнд нэвчих) байгаа нь урт хугацаанд байгаль орчны эрсдэлийг дагуулж болзошгүй.



Өнөөгийн байдал. Петрочнагийн талбайн хатуу хог хаягдлын түр цэг



Өрмийн шингэн хаягдлыг бүр мөсөн булшлахад ашиглаж буй хаягдлын сан

- Төв аймгийн Заамар сумаас баруун хойд зүгт байрлах “Уул уурхайн үндэсний олборлогч” ХХК-ийн шороон ордын алтны уурхай. Томоохон хөндийд байрлах том хэмжээний шороон ордоос алт олборлож байна. Алтны судал бүхий хайрга хөндийн ёроолоос 40-50 метрийн гүнд оршиж байгаа тул их хэмжээний хаягдал шороог зөөвөрлөж, түр овоолох шаардлага гардаг. Алт ухах газрын өнгөн хэсгийн барагцаагаар 30 см хөрсийг хуулан авч, дараа нь нөхөн сэргээлтэд ашиглахын тулд тусад нь овоолго үүсгэсэн. Бидний очсон хэсэгт алтны судал бүхий хайрга олборлох уурхайн үйл

ажиллагаа үндсэндээ дууссан байв. Харин одоо шороо асгаж, уурхайн нүхийг дүүргэн битүүлэх, гадаргын рельефийг хэлбэршүүлэн засч, овоолсон өнгөн хөрсөөр хучих (техникийн нөхөн сэргээлт), өвс ургамал тарих (биологийн нөхөн сэргээлт) зэрэг ажил хийж байна. Орон нутгийн малчид тухайн газрыг хожмоо бэлчээрийн зориулалтаар ашиглана хэмээн найдаж, Засаг даргийн хүсэлтээр нөхөн сэргээж буй талбайд согоовор өвс, гиш хоёрын үрийг хольж суулгасан. Өнөөдрийн байдлаар өвс ургамал тарих ажил амжилттай хийгдсэн нь илт. Гэсэн хэдий ч өвс тариад удаагүй газарт мал орж, ургаж эхэлж буй нялх өвс ургамлыг гэмтээх асуудал тулгарч байна. Уурхайнхан энэ асуудлыг шийдэх талаар орон нутгийн малчидтай хамтарч ажиллаж байна.

Заамар сумын баруун хойд зүгт байрлах “Уул уурхайн үндэсний олборлогч” ХХК-ийн шороон ордын уурхайн нөхөн сэргээлтийн талбайд өнгөн хөрсөөр хучиж буй байдал





Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд байгаль орчны асуудлыг тусгах, гэрээ байгуулах талаар чадавх бэхжүүлэхэд өгөх зөвлөмж

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээн дэх байгаль орчны холбогдолтой заалтууд

Өмнө авч үзсэнчлэн Монгол Улс томоохон ашигт малтмал, газрын тосны олборлолтын үндсэн үйл ажиллагааны хувьд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хувьд харьцангуй ойлгомжтой, цогц хууль тогтоомжтой. **Хэрэв** суурь үнэлгээ, дагалдах байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хоёрыг **зохистой хийж чадвал** дараах чиг үүрэг бүхий төлөвлөлтийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- Тодорхой нэг төслийн эрсдэл, үзүүлэх нөлөөллийг тооцоолж, тодорхойлох
- Эрсдэлийг удирдаж, нөлөөллийг бууруулахын тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээг тодорхойлох
- Эхний жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг урьдчилсан байдлаар бэлтгэж өгдөг.

Жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө бол илрүүлсэн байгаль орчинд учирч болзошгүй эрсдэлийг бууруулж, хяналт тавихын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний стратегийн зорилтуудыг тодорхой, төсөвтэй, хуваарьт ажил болгон буулгадаг. Ийм байдлаар **хэрэв зохистой хийж чадвал** байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгаж болохуйц байгаль орчныг хамгаалах, хяналт тавих хамгийн тохиромжтой үүрэг хариуцлагыг тогтоож өгдөг. Энэ шалтгаанаар Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, хяналт тавих үүргээ хэлбэрэлтгүй биелүүлэхийг шаардсан хатуу чанд заалт оруулж, тухайн жилийн батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд нэмэлт өөрчлөлт хэлбэрээр тусгаж байх нь зүйтэй. Хэрвээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөний баримт бичиг нь хэмжээний хувьд Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд хавсаргахад хэтэрхий том байвал үйл ажиллагааны мөн чанар, хуваарь, байршил зэрэг тус төлөвлөгөөний байгаль орчин хамгаалах, хяналт тавихтай холбоотой гол асуудлыг хамарсан зүйл заалтыг л Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний үндсэн хэсэгт тусгавал тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага илүү тодорхой болох юм.

Нэг уулзалтын үеэр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн нөхөн сэргээлтийн арга хэмжээний хугацаа, байршил, тайлбар, төсвийн талаар компанийн хүлээх тодорхой үүрэг хариуцлагыг Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд оруулж өгөх шаардлагатайг онцгойлон дурдаж байв. Мөн уулзалтаар аймаг, сумын харгалзах байцаагчид талбайд хяналтаар очих боломжийг хангахын тулд тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилд төлөвлөсөн эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх чухал ажлуудаа (жишээ нь: үржил шимт өнгөн хөрсийг нөхөн сэргээлтэд ашиглах зорилгоор зохистойгоор хадгалах, бохирдсон талбайг цэвэрлэх гэх мэт) аймаг, сумын байцаагч нарт урьдчилан мэдэгдэх үүрэг хүлээх ёстой хэмээж байв. Ийм үүрэг нь жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтсан үүрэг ч гэлээ Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний тусдаа заалт болж бататгаж өгвөл зохистой.



Ерөнхийдөө дараах шалтгаанаар Аймаг, сумын түвшний захиргааны байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээг Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгахыг хүчтэй дэмжиж байв. Үүнд:

- Өнөөг хүртэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс орон нутгийн ард иргэдэд мэдээлэл хүргэх, саналыг нь сонсох уулзалт, хэлэлцүүлэг хийх ажил хангалтгүй байна. Тодруулбал, нөлөөлөлд хамгийн их өртөж буй сумын ард иргэд аливаа уурхай, газрын тосны төсөл ямар шат дараалалтай явагддаг талаар ойлголт муу байна. Иймээс, нутгийн ард иргэд олборлолтыг ямар ч үр өгөөжгүй, зүгээр л тэдний газрыг сүйтгэж байгаа үйлдэл гэж хардгаас ерөнхийдөө олборлох үйлдвэрлэлд итгэлгүй болоход хүргэжээ.
- Нөлөөлөлд хамгийн их өртсөн сумын ард иргэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөлтийн үйл явц, үүнтэй холбогдсон байгаль орчныг хамгаалах үүргийн талаар ойлголт багатай байна. Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн одоогийн зохицуулалтын дагуу (8.7-р заалт) байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэг л хувийг төсөл хэрэгжих сумын ЗДТГ-т өгдөг. Энэ байдал нь олон нийт уг мэдээллийг олж авах боломжийг маш бага болгожээ.
- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ нь олон нийт үзэх боломжтой, хүртээмжтэй баримт бичиг байх нь зүйтэй. Мэдээлэл түгээх төлөвлөгөөнд олон нийтэд мэдээлэл өгөх уулзалт зохион байгуулах, ард иргэд чөлөөтэй үзэх боломжтой мэдээллийн самбарт мэдээлэл хадах, сумын цахим хуудсанд мэдээлэл нийтлэх зэрэг арга замуудыг тусгах хэрэгтэй. Жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүрэгт ажлуудыг Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгаж өгснөөр олон нийт төр захиргааны байгууллагын зүгээс олборлох үйлдвэрлэлд тавьж буй хяналт, компаниудын байгаль орчныг хамгаалах үүрэг хариуцлагын талаар илүү сайн ойлголттой болно.
- Ийм Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний бүтэцтэй болсноор компанийн байгаль орчны чиглэлээр хийсэн ажлууд олон нийтэд илүү нээлттэй, ил тод болох юм.

Уулзалтанд оролцогчдын цөөн хэд нь л Монгол Улсын байгаль орчны тухай хууль тогтоомж хангалттай сайн, тэр хууль тогтоомжид байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулах шаардлага аль хэдийн багтсан, олборлох салбарын аж ахуйн нэгжүүд тэрхүү хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй учраас байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тодорхой заалтуудыг нэмэлтээр Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгах шаардлагагүй хэмээн үзэж байв. Гэхдээ уг тайлангийн үр дүнгээс харахад Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд зүгээр л Монгол Улсын хуулийг дагаж мөрдөнө гэж заах нь байгаль орчныг хамгаалхад учир дутагдалтай. Энэ нь дараах хэдэн шалтгаантай. Үүнд:

- Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд байгаль орчны холбогдолтой заалтыг ийнхүү хязгаарлаж өгөх нь сумын иргэдэд компанийн байгаль орчныг хамгаалах үүрэг хариуцлагын талаар зохих дэлгэрэнгүй мэдээллийг өгч чадахгүйд хүрнэ.
- Орон нутгийн ард иргэд компанийн байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүрэг хариуцлагын талаар тэр бүр мэдлэг, мэдээлэлгүй байснаас тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчны үүргээ хангалтгүй биелүүлсэн байдлаа олон нийтээс нуун далдлах боломжийг олгоно.



- Одоогийн байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд холбогдох хуулийн шаардлагыг биелүүлэхгүй байна (тухайлбал, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлуулах). Тиймээс Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд зүгээр л холбогдох хууль тогтоомжоос эшлэн оруулах нь тэдний хууль биелүүлэх байдлыг дээшлүүлэхгүй нь тодорхой.

Байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах

Байгаль орчны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг ашиглах бодлогын чиглэлийг гаргаж, Монгол Улсын байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжид оруулсан тул аливаа төслийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг төслийн тухайн жилийн батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд оруулна гэж бодож байна. Нөхөн сэргээлт хийх үүрэг хариуцлагын тухайд жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хугацаа, байршил, тайлбар, төсвийн хувьд компанийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой заасан заалтыг Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд оруулж өгөх нь зүйтэй.

Аливаа төслөөс байгаль орчинд учруулах хор хохирлыг бууруулахын тулд байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах аргыг ашиглах туршлагыг олон улсын түвшинд нэвтрүүлээд арван гаран жил өнгөрчээ. Гэвч энэ бол олборлолтын талбайд байгаль орчны чиглэлээр хүлээсэн үүргээ зөвшөөрөгдөх түвшинд биелүүлэхээс зайлсхийх буюу нөхөн олговор төлөөд мултрах хялбархан арга гэсэн ойлголтыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад төрүүлж хэрхэвч болохгүй. Шийдвэр гаргагчид ямар ч төсөлд байгаль орчны дүйцүүлэн хамгаалах арга ашиглах зөвшөөрөл олгохоос өмнө тухайн компани эдийн засгийн нөөц бололцоондоо тулгуурлан төслийн байгальд үлдээх ул мөрийг арилгах, алдагдсан экологийн төлөв байдлыг нь эргүүлэн сэргээхийн тулд боломжит хамгийн сайн техник технологийн авч ашиглах хүсэл эрмэлзэлтэй байгаагаар нотлон харуулах ёстой. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ бол зөвхөн эдгээр хүчин чармайлтыг гаргасны дараа үлдсэн сөрөг нөлөөлөл, алдагдсан экологийн тэнцвэр, үнэ цэнийг сэргээхэд л бодолцож үзэх нэг хувилбар билээ. Түүнчлэн, дүйцүүлэх аргыг зөвшөөрөхөөс өмнө дараах нөхцөл бүрдэх ёстой. Үүнд:

- Талбайг сайжруулахын тулд (тухайлбал дүйцүүлэх хамгаалах) төлж буй төлбөр нь тухайн газарт ашигт малтмал, газрын тосны үйл ажиллагаа явуулсны улмаас алдагдсан экологийн үнэ цэнийг зохистойгоор төлж барагдуулахуйц байхыг магадлахын тулд экологийн дүйцүүлэх зардлыг хэмжих, тооцоолох баттай аргачлалыг олж тогтоосон байх ёстой.
- Газрын ирээдүйн ашиглалтыг тасалдуулснаас алдагдсан боломжийн үнэ цэнийг дүйцүүлэн тооцоолоход ашиглах дүйцүүлэх хамгаалсан талбайн байгаль хамгаалах ажиллагааг магадлах арга байх ёстой.
- Байгаль орчны бус дүйцүүлэх (жишээлбэл, дэд бүтэц хөгжүүлэх дэмжлэг) аргыг хэзээ ч талбайд учруулсан экологийн үнэ цэнийн алдагдлыг нөхөх зорилгод орлуулан ашиглаж болохгүй.

Зам ашиглалтын менежмент

Энэхүү томилолтын ажлыг гүйцэтгэх явцад уулзсан олон хүн олборлогч компаниуд тал нутагт дур мэдэн батлагдаагүй шороон замыг ашиглах явдал хэрээс хэтэрсэн, үүний улмаас бэлчээрийн өвс ургамлын ургалт муудаж байгаа асуудалд санаа зовниж буйгаа удаа дараа илэрхийлж байв. Захиргааны байгууллага, ард иргэд эдгээр замыг дараах



гурван зорилгоор гаргадаг байна. Үүнд: i) Аймгийн албан ёсны замыг сум хүрэх замтай холбох, ii) Сум хоорондын болон сумаас баг орох зам iii) Хувь хүний эзэмшил өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслан гэх мэт рүү хүргэх зам байна. Хэдийгээр зарим замын байршлыг барагцаагаар GPS-ийн мэдээлэл, газрын зурагт оруулсан байгаа ч эдгээр маршрутын нэг нь ч батлагдсан төлөвлөлт, трассгүй болох нь харагдсан. Тал нутгийн ландшафт хавтгай, ургамал сийрэг ургадаг онцлогтой учраас хэрвээ эдгээр чиглэлийн замын зорчих гадаргууг сайжруулах ямар нэгэн ажил өмнө хийгдэж байсан бол цөөн хэдийнх нь л зорчих гадаргууд засвар, арчлалт хийдэг нь илт. Хавар цас мөс хайлахтай зэрэгцэн хур тунадас ихээр орсноор тээврийн жолооч нар шороон зам дээр тогтсон усархаг, шавартай хэсгээр явахаас зайлсхийж, замаас гарч, замын хажуугийн ургамал ургасан илүү биетэй хэсгээр машинаа жолооддог байна. Үүний улмаас, машин нэлээд олноороо явдаг замын маршрутын хувьд 30-100 метрийн өргөн газрыг хамарсан олон салаа зам үүсч, бэлчээрийн хөрс болоод түүнийг элэгдлээс хамгаалдаг зүлэг ногоог ихээр гэмтээдэг байна. Тухайлбал, Заамар орох зам, Петроचनाгийн XXI талбай хүртэлх зам зэрэг ихээр эвдэрсэн зарим газар нүцгэрч, элсэн толгод үүсч, улмаар цөлжилт эрчимтэй явагдаж байна.

Олборлох салбарын аж ахуйн нэгж батлагдсан тээвэрлэлтийн маршрутын замаас гадна ард иргэдийн ашигт малтмал, газрын тосны олборлолтын талбай руу зорчихдоо ашигладаг албан бус шороон замаас бүтсэн шинэ замын сүлжээ бий болгож байна. Засгийн газраас баталсан одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй журмын дагуу бол тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн талбай хүрэх замын маршрут батлуулах хүсэлтээ Монгол Улсын замын зөвлөх инженерийн дэмжсэн дүгнэлтийн хамтаар харгалзах аймгийн Засаг даргад гаргахыг шаарддаг. Гэсэн хэдий ч маршрутын дагуу замын гадаргууг хэрхэн сайжруулах талаар нарийн шаардлага тавиагүй байдгаас уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зам нь өгсүүр газарт нимгэн хучилт хийж сайжруулсан, тэгш талд энгийн шороон зам байсан хэвээр байна. Үүнээс шалтгаалан, хүнд даацын автомашин хур тунадас элбэг үед зөөлөн шавартай замаар явахаас зайлсхийдэг, хяналт сул, хуулийн хэрэгжилт хангалтгүйгээс замгүй газраар явж зөрчил гаргагчдад зохих шийтгэл ногдуулахгүй байгаа учир улам олон салаа зам үүсч, улмаар тал газрын хөрсний элэгдэл жил ирэх бүр нэмэгдсээр байгаа нь харагдсан. Дараах Петроचनाгийн олборлолтын XXI талбайн замын зургаас хүнд даацын автомашин тээвэрлэлтээс үүдэлтэй хөрсний эвдрэлийг тодорхой харж болно.



XXI талбайн чиглэлийн замд хяналтгүй тээвэрлэлт хийж буй хүнд даацын автомашин хөрс эвдэрч, ургамлын нөмрөг устахад хүргэж байгаа нь

Замтай холбоотой хээр талын экосистемд учирч буй хохиролд зөвхөн аймаг, сумын захиргааны байгууллага, олон нийт болон олборлох салбарын компаниудын хамтын хичээл зүтгэл, дэмжлэгтэйгээр л хяналт тавьж, зогсоож чадна. Жолооч нар нойтон болон бартаатай замаас гарч, өвс ургамал ургаж буй газар жолоодохыг болиулах зорилгоор замын гадаргууд зохих сайжруулалт, арчлалтыг хийх, судлагдаж батлагдсан замын трасстай болох тал дээр түлхүү ажиллах ёстой. Салбарын зүгээс байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ бол хоёул компаниудыг замын менежмент хэрхэн хийх талаар мэдээлэл өгч, удирдан чиглүүлэхэд ашиглахад тохиромжтой төлөвлөлтийн баримт бичиг болох нь гарцаагүй. Компанийн урт хугацаанд тээвэрлэлтийн замыг хэрхэх төлөвлөгөөг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэг бүрэлдэхүүн хэсэгт оруулбал зохино. Харин Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг тэрхүү урт хугацааны төлөвлөгөөний биелэлтийг жил бүр хянах, удирдах арга хэрэгсэл болгон ашиглаж болох юм. Мөн Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд компаниудаас дараагийн жил ашиглалтын талбайд нь шаардлагатай нэмэлт замын маршрутын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг урьдчилан мэдээлж, хүсэлт гаргахыг шаардсан заалтыг оруулах боломжтой. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд шаардах мэдээлэлд: тухайн чиглэлийн замын трасс, солбицол бүхий замын зураг, замын тодорхойлолт (тухайлбал, өнгөн хөрсний зузаан, хучилт хийсэн талбайн өргөн) болон замын гадаргууг сайжруулахын тулд хийхээр санал болгож буй ажлууд (замын нойтон шаварлаг хэсгийг дүүргэх хайрга, дайрга гэх мэт) зэрэг мэдээлэл орж болох юм. Мөн Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчийг ашиглалтаас гарсан зам, дараагийн жилд нь тухайн замыг нөхөн сэргээх төлөвлөгдсөн ажлын талаар мэдээлэл хүргүүлэхийг шаардсан заалт оруулах боломжтой. Цаашлаад, зам ашиглалтын



менежментийн төлөвлөгөөг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгаж болно.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг боловсруулсан ажлын хэсэгт оролцсон хүмүүс

Сумын захиргааны байгууллагын төлөөлөгч, орон нутгийн ард иргэдийн төлөөллийн зохих санал дэмжлэгийг авалгүйгээр Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг үр дүнтэй байгуулж, хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг уулзалтад оролцсон нэлээд хэдэн хүн илэрхийлсэн юм. Дорнод аймагт Засаг дарга аймгийн Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний загварыг боловсруулах үүрэгтэй ажлын хэсгийг томилон байгуулсан. Уг ажлын хэсэгт Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын аймгийн дэд зөвлөлийн гишүүн, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч зэрэг хүмүүс багтсан.

Дашбалбар сумын засаг дарга, Шинь Шинь компани хооронд саяхан байгуулсан уурхай байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээний төсөлд тухайн гэрээний хүрээнд байгуулах Хамтын ажиллагааны хороо (өөрөөр хэлбэл, ажлын хэсэг)-ны бүтэц бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүргийн талаар гэрээний гурван заалтад оруулжээ.

5.1-д: Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороог төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

5.2-т: Хамтын ажиллагааны хороо нь есөн хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хамтын ажиллагааны хорооны гишүүдийг сумын Засаг дарга томилж, чөлөөлнө.

5.3-д: Зөвлөл нь энэхүү гэрээг байгуулах үйл явц болон хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

Цаашид ч төсөл бүрт өөр өөрийн гэсэн онцлогтой Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг байгуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс үүнтэй төстэй ажлын хэсгийг Засаг дарга нар томилон байгуулсаар байх болов уу. Шинь Шинь компанийн гэрээнд заасны адил аливаа хамтын ажиллагааны хороо буюу ажлын хэсэг нь дараах талуудын тэгш оролцоо бүхий төлөөллийг багтаах хэрэгтэй. Үүнд:

- Аймаг эсвэл сумын захиргааны байгууллага
- Сумын ард иргэд эсвэл төрийн бус байгууллагын төлөөлөл (жишээ нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга)
- Уул уурхай компани

Өмнөх байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хэсэгт дурдсанаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүр үнэлэх зорилгоор дээрхтэй төстэй ажлын хэсгийг байгуулсан байгаа. Хэрэв байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг үнэлэх ажлын хэсэгт багтсан гишүүдийг мөн ижил компанитай байгуулж, жил бүр шинэчлэх ёстой орон нутагтай хамтран ажиллах гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэгтэй хороо буюу ажлын хэсэгт оруулж чадвал тодорхой өгөөж, үр дүн гарах болно. Тэд бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны чиглэлээр хүлээх үүргийг тогтоож, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тодорхой оруулж, үр дүнтэй хяналт тавиж байгаа эсэхийг бататгахад хамгийн тохирох хүмүүс юм.



Мэдээлэл цуглуулах нэг уулзалтаар тус ажлын хэсэг орон нутгийн түвшинд олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болох юм гэсэн санал гарсан. Ингэснээр цахим сүлжээнд холбогдоогүй малчид зэрэг хүмүүст Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний үүргийн тухай мэдээллийг түгээх боломжтой болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах үйл явцын ил тод байдлыг нэмэгдүүлэх, одоо ажиглагдаж буй орон нутгийн иргэдийн олборлох салбарт үл итгэх байдлыг багасгахын тулд уг ажлын хэсэг уул уурхайн нөлөөлөлд өртсөн газруудад тогтмол уулзалт, хэлэлцүүлэг (тухайлбал, сумын буланд уулзалт хийх) төлөвлөх, зарлах, зохион байгуулах зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэж болох юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ болон тэдгээрийн талаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах гурван ажлыг ганц ажлын хэсэгт даалгах нь төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зохих дэмжлэггүйгээр амжилт олохгүй. Ажлын хэсэгт орсон төрийн байгууллага, компанийн төлөөллүүдийн гүйцэтгэх үүрэг нэмэгдэж байгаатай холбоотойгоор ажлын хэсгийн ажлаа хийхэд ажлын цагийнхаа тодорхой хэсгийг зориулах боломж олгох үүднээс тэдэнд зохих эрх өгч, уян хатан байх хэрэгтэй. Мөн түүнчлэн, ажлын хэсэгт багтсан орон нутгийн ард иргэд (төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан биш байх), төрийн бус байгууллагын төлөөллүүдэд ажлын хэсгийн ажилд ач холбогдол өгч, өөрийн хувь нэмрээ оруулахад нь түлхэц болох үүднээс тохирох шан харамж өгвөл зохистой. Тусгай зөвшөөрөл эзэмшигч бол уг мөнгийг гаргах боломжтой, гаргавал зохих тал бөгөөд тэдний уг санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүргийг Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгаж болох юм.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналт, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ

Одоогийн байдлаар байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах асуудал дээр аймаг, сумын захиргааны байгууллага, Засгийн газрын яамд хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа сул байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг үнэлэх үүрэгтэй ажлын хэсэг компанийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргийн биелэлтийг 'хангалтгүй' гэж дүгнэсэн байхад зөрчил гаргасан компанийн үйл ажиллагааг зогсоох, торгууль ногдуулах эрхтэй аймаг, Засгийн газрын агентлагууд тэдний гарган тавьсан асуудал, дүгнэлт зөвлөмжийг хайхарч үзээгүй олон тохиолдол гарчээ.

Хэд хэдэн тохиолдолд ажлын хэсэг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн дүгнэлтийг цаг хожимдуулж хүргүүлснээс тухайн жилийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд садаа болжээ. Гэсэн хэдий ч дүгнэлтийг хожимдуулж хүргүүлэх нь байгаль орчныг хамгаалах стандарт хангаагүй практиктэй хэвээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, торгуулиас бултах боломжийг компаниудад олгодог хуулийн цоорхой байж болохгүй.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах үүднээс муу гүйцэтгэлтэй тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд ногдуулдаг үйл ажиллагааны хязгаарлалт, торгууль шийтгэл байх ёстой. Дашбалбар сумын засаг дарга, Шинь Шинь компани хооронд саяхан байгуулсан уурхай байгуулах чиглэлээр хамтран ажиллах гэрээний төслийн 7.2-т:



“Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх бөгөөд ингэхдээ тухайн зөрчлийн талаарх Хамтын ажиллагааны хорооны саналыг харгалзан үзнэ” гэж заасан.

Түүнчлэн 7.3-т дараах заалтыг оруулжээ:

Талуудын хооронд гэрээтэй холбоотой маргаан гарвал талууд харилцан зөвшилцөж, эвзүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв зөвшилцлийн аргаар маргаанаа шийдвэрлэж чадахгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

Хэрэв жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах талаар компанийн үүрэг нь Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн тодорхой нэг хэсэгт орох юм бол компани байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тохиолдолд эдгээр заалт нь нэг талаас төрийн байгууллагын хуулийн хэрэгжилтийг хангуулах арга зам, нөгөө талаас тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан зөрчлөө арилгах арга хэмжээ авах магадлалыг нэмэгдүүлэхээр харагдаж байна. Гэрээний загвар эцсийн байдлаар бэлэн болсон тул хуулийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой бодлого зөв чигт явж байгааг нягтлахын тулд эдгээр заалтын хүчийг МЕРИТ төслөөр хянуулахыг зөвлөж байна.

Чадавх бэхжүүлэх, сургалт явуулах хэрэгцээ

Орон нутгийн төрийн бус байгууллагын төлөөллүүдтэй хийсэн уулзалтаар оролцогчид хэрэв компаниуд байгаль орчныг хамгаалах чиглэлээр ямар нэгэн ажил хэрэгжүүлээгүй бол үйл ажиллагааг нь бүрмөсөн зогсоодог болбол нэмэлт ямар нэгэн байгаль орчин хамгаалах сургалт явуулах шаардлагагүй байх байсан гэж үзэл бодлоо илэрхийлсэн. Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах арга хэрэгслийг ашиглах аваас компаниуд гэнэтхэн өөрийн байгаль хамгаалах ажлыг өндөр түвшинд хэрэгжүүлж эхлэх учраас үнэлгээ, дүгнэлт хийх сургалт явуулах шаардлагагүй хэмээн үзсэн байна.

Төрийн бус байгууллагын төлөөлөл асуудлыг нухацтай авч үзэлгүйгээр хэлсэн авч түүний үүгээр өгүүлсэн санаа их чухал юм. Гэхдээ МЕРИТ чадавх бэхжүүлэх гэрээ байгуулж, энэ чиглэлийн ажил эхлүүлэхээс өмнө Монгол Улсын Засгийн газраас байгаль орчны чиглэлээр хүлээх үүргээ удаа дараа хангалтгүй гүйцэтгэж буй компаниудад Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу мөнгөн торгууль ногдуулах, үйл ажиллагааг нь зогсоох зэрэг зохих хариуцлага хүлээлгэж байгаа эсэхийг бататгах хэрэгтэй.

Хуулийн хэрэгжилтийг хангана хэмээн үзэж байгаль орчныг хамгаалахад нэн даруй өгөөжөө өгөхүйц аймаг, сумын түвшинд чадавх бүрдүүлэхэд чиглэсэн сургалт явуулбал зохих гурван талбар харагдаж байна. Үүнд:

- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх
- Хорт болон аюултай бодисын удирдлага болон аюултай хог хаягдлыг устгах арга зам
- Төслийн амьдралын мөчлөгийн үе шатууд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг удирдах



Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх

Монгол Улс нөхөн сэргээлттэй холбоотой хэд хэдэн үндэсний стандартыг боловсруулан гаргасан хэдий ч практикт олборлох салбарын аж ахуйн нэгжүүдийн эдгээрийг хэрэгжүүлэх байдал нь төсөл бүрт, цаашлаад сумаас сумд харилцан адилгүй байна. Нөхөн сэргээлтийн жишиг тогтоохуйц ажлыг төлөвлөж, гүйцэтгэсэн жишээг Заамар сумын баруун хойд зүгт байрлах Монголын “Уул уурхайн үндэсний олборлогч” (УУҮО) ХХК-ийн шороон ордын уурхайгаас олж харсан. Харин Баяндун сумын хойд зүгт байрлах шороон орд ашиглаж буй уурхай болон Петроцайнагийн XXI талбайд нөхөн сэргээлтийн үр дүн харьцангуй муу байгаа нь ажиглагдсан. Түүнчлэн, Баяндун сумын хойд зүгт нөхөн сэргээлтийн ажил огт хийгдээгүй, бичил уурхай ашиглаж байгаад хаясан шороон ордтой танилцсан.

Энэхүү томилолтын ажлын явцад уулзсан хүмүүс нөхөн сэргээлтийн талаарх сургалт ихээхэн хэрэгцээтэй байгааг цохон тэмдэглэж байв. Нэг оролцогч нөхөн сэргээлтийн ажлыг сайн болон муу хийсэн жишээ болгон заах бодит талбай байдаггүй нь олборлолтын талбайд үнэлгээ хийхэд хүндрэл учруулдаг гэж байв. Эндээс дүгнэн хэлэхэд олборлох салбарт хамаарах байгаль орчныг хамгаалах хамгийн чухал арга хэрэгслүүдийн нэг болох хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг хангуулах явдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг тул МЕРИТ төслийн хувьд нэн тэргүүнд сургалт явуулах сэдэв нь нөхөн сэргээлт байвал зохино.

Үр дүнтэй байх үүднээс энэ нь дараах олон асуудлыг хөндсөн “эхлэхээс дуусах хүртэл” бүх үйл явцыг хамарсан сургалтын модуль байх хэрэгтэй. Үүнд:

- Уул уурхайн үйл ажиллагаанаас өмнөх байгалийн хөрсний шинжилгээ (тухайлбал өнгөн хөрсний зузаан, хөрсний үе давхаргуудын бүтэц, үржил шимт буюу органик агууламж)
- Олборлолт явуулахаас өмнө болон түүний явцад үржил шимт өнгөн хөрсийг хуулж, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглах зорилгоор зохистойгоор хадгалах, түр овоолго хийх, мөн тогтворжуулах
- Олборлолт явуулахаас өмнө болон явцад гадаргын ба газрын доорх усны нөөцийн менежмент (бага хэвгийтэй усны нөөцийг хамгаалах зорилгоор)
- Техникийн нөхөн сэргээлтийн явцад хаягдал усан сан, ухшийг битүүлэх, газрын хөрсийг буцаан хэлбэрт нь оруулах, тогтворжуулах
- Дараа нь талбайд өнгөн хөрсөөр хучиж, мөн салхинд элэгдэхээс хамгаалахийн тулд хөрсийг тогтворжуулах арга хэмжээ авах (сүрэл ашиглан хөрс сайжруулалт хийх гэх мэт)
- Ургамал зүлэг тарих, тэр дундаа ямар төрөл зүйлийн ургамал сонгох талаар зөвлөгөө өгөх зэрэг багтана.

Сургалтад оролцогчдод янз бүрийн талбайд очиж, нөхөн сэргээлтийн ажил хэрхэн хийгдсэнийг нүдээр үзэж танилцах боломж олгох бүрэлдэхүүн хэсэг оруулах нь чухал. Заамар сумын баруун хойд зүгт байрлах шороон орд олборлогч “Уул уурхайн үндэсний олборлогч” ХХК-ийн Төслийн менежер И.Түвшинтөгс оролцогчдыг практикт нөхөн сэргээлтийн ажлыг хэрхэн хийдгийг харуулах, талбай дээр нь сурган дадлагажуулах үүднээс өөрийн талбайд зочлон ирж, сургалт явуулахыг санал болгосон. Ингэснээр сургалтад оролцогчид хариуцлагатай нөхөн сэргээлтийн жишгийн талаар тодорхой дүр зурагтай болох юм.



Хорт болон аюултай бодисын удирдлага болон аюултай хог хаягдлыг устгах арга хувилбар

Компаниудын хорт болон аюултай бодисын удирдлага, аюултай хог хаягдлыг устгаж буй байдал сум болгонд, цаашлаад төсөл бүрт ялгаатай байгаа бөгөөд энэ асуудлыг нарийн заасан үндэсний стандарт дутмаг байна. Уг томилолтын ажлын хүрээнд уулзсан хүмүүс нөхөн сэргээлтийн адилаар энэ чиглэлээр сургалт явуулах шаардлагатай хэмээн ахин дахин онцолж байв.

Хэрэв МЕРИТ энэ сургалтыг явуулах бол сургалтын материалд дараах асуудлыг оруулахыг зөвлөж байна. Үүнд:

- Аюултай ачаа бараа тээвэрлэх (талбайгаас гадагш болон талбай руу)
- Уурхайн талбайд байгаа хорт болон аюултай бодис, түүнийг агуулсан материалын мэдээллийн сангийн менежмент
- Талбай дахь хорт болон аюултай бодис бүхий материалын ашиглалт ба хадгалалт (давхар савлагаа, хамгаалалт далан барих, асгарах, алдагдах тохиолдолд авах хариу арга хэмжээ)
- Энгийн хог хаягдлыг хаях, бууруулах, хадгалах, устгах (жишээлбэл, барилгын хог хаягдал, уурхайн кэмпийн ахуйн хог хаягдал гэх мэт)
- Бохирдсон хөрс, өрөмдлөгийн хаягдал, химийн хорт хог хаягдлын талаар заасан хортой хог хаягдлыг устгах тогтолцоо зэрэг багтана.

Төслийн амьдралын мөчлөгийн үе шат болон байгаль орчны нөлөөллийн хосолсон сургалт

Аймаг болон Улаанбаатар хот дахь төрийн байгууллагын удирдах ажилтантай хийсэн уулзалтаар олборлох салбарын үйл ажиллагаа буюу төслийн амьдралын мөчлөгийн үе шатууд болон тэдгээр үе шат бүрийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэргэжлийн мэдлэг, энэ талаар мэргэшсэн байдал аймаг, сумын түвшинд дутмаг байгаа талаарх асуудлыг хөндсөн. Гардан хийж буй хүмүүс нь олборлолтын үйл ажиллагаа ба байгаль орчны эрсдэлийн хоорондох уялдаа холбоо, эдгээр эрсдэлийг бууруулах байгаль орчны менежментийн арга хэмжээний үр ашгийг бүрэн ойлгоогүй байх талтай учраас энэ чиглэлийн туршлага дутмаг байдал нь төрийн хяналт шалгалтын ажлын үр дүнг бууруулах талтай. Хэрэв жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх үүрэгтэй ажлын хэсэг үүнтэй адил туршлага дутмаг байх аваас энэхүү үнэлгээний үр дүн буурна. Тиймээс МЕРИТ хоорондоо холбоотой энэ хоёр сэдвийг агуулсан хосолсон сургалтыг явуулахыг тэргүүлэх чиглэл болгохыг зөвлөж байна. Энэхүү сургалтад дараах дэд сэдвүүдийг багтаах нь зүйтэй. Үүнд:

Нэгдүгээр хэсэг: Олборлох салбарын төслийн амьдралын мөчлөгийн үе шатууд

СЕСМИМ төслийн төлөөллүүдтэй хийсэн уулзалтын үеэр Төслийн Монгол дахь захирал М.Звиеринк тус төслийнхөн уурхайн амьдралын мөчлөгийн үе шатуудын талаар олон нийтэд боловсрол олгоход зориулсан сургалтын хөтөлбөр бэлтгэсэн хэмээн дурдсан. Тиймээс МЕРИТ төслийн зүгээс сургалтын материал боловсруулж, санал болгохоосоо урьтаж СЕСМИМ төслийнхөнтэй уг модулийн талаар уулзаж, ярилцах нь зүйтэй. Гэвч ашигт малтмал, газрын тос олборлох төслийн аль алиных нь хувьд сургалтын модульд амьдралын мөчлөгийн дараах үе шатыг оруулахыг зөвлөж байна. Үүнд:



- Хайгуул, бүтээн байгуулалтын эрх олж авах төлөвлөлт, менежмент
- Хайгуул
- Уурхайн кэмп, дэд бүтэц байгуулах
- Нөөц олборлоход зориулсан талбайн бэлтгэл ажил (Жишээлбэл, газрын тос олборлоход өрөмдлөг хийх, уурхайн өнгөн хөрс, хаягдал шороог зайлуулах)
- Нөөц олборлолт, талбай дээрх боловсруулалт
- Хаалт ба нөхөн сэргээлт
- Хэрэв мөрдөгддөг бол хаалтын дараах үйл ажиллагаа (жишээлбэл, хяналт) орно.

Хоёрдугаар хэсэг: Төслийн сөрөг нөлөөлөл болон нөлөөлөл бууруулах гол арга

СЕСМИМ төсөл 2018 оны ажлын төлөвлөгөөндөө байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаар бүрэлдэхүүн хэсгийг тусгасан. Гэвч тэдний голлон анхаарч буй зүйл нь цаашид үнэлгээний практикийг олон улсын стандартад хүргэхийн тулд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаар бодлого, зохицуулалтын тогтолцоо, түүнийг ёсчлон биелүүлэх байдлыг бэхжүүлэх зорилго бүхий өндөр түвшний хууль эрхзүйн, зохицуулалтын, менежментийн санаачилгууд байна. Үүнээс шалтгаалан, тэдний тавьж буй зорилтууд нь бидний энд санал болгож буй ажлаас ялгаатай байна. Гэсэн хэдий ч МЕРИТ сургалтын материал шинээр боловсруулан, санал болгохоосоо өмнө тус сургалтын модулийн талаар СЕСМИМ төсөлтэй ярилцах нь зүйтэй.

Сургалтын модулийн энэ хэсэг нь олборлох салбарын үйл ажиллагаанаас үүсч болзошгүй гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход голлон анхаарна. Сургалтад дараах дэд сэдэв багтвал зохино. Үүнд:

- Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг, түүний онцлогийг тодорхойлох аргачлал, ялангуяа төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн хувьд
- Дээрх олон нөлөөлөлд хүргэж буй хүчин зүйлсийн уялдаа холбоо
- Нөлөөллийн эрсдэлийг бууруулах үндсэн стратеги
- Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын үр дүн, өгөөжийн түвшинг бүртгэх хяналтын гол стратеги

Энэхүү тайлангийн сүүлчийн хуудас Хүснэгт 2-т уг модульд багтаж болох сургалтын агуулгын боломжит сэдвүүдийг жишээ болгон оруулсан.

Хоёрдогч чадавх хөгжүүлэх

Мэдээлэл цуглуулах уулзалтаар чадавх бүрдүүлэх шаардлагатай хэмээн дараах гурван нэмэлт талбар нэлээд дурдагдсан.

Газрын доорх усны нөөцийн үнэлгээ, хяналтын систем

Төсөл эхлэх үеийн газрын доорх усны нөөцийн суурь үнэлгээ хийх, олборлох үйлдвэрлэлээс үүдэлтэй газрын доорх усны нөөцийн тоо хэмжээ, чанарт гарч буй өөрчлөлтийг хэмжих зохих хяналт-шинжилгээний системийг хэрэгжүүлэх чадвартай байх нь дараах үйл ажиллагаанд нэн чухал юм. Үүнд:

- Газрын тос олборлолт: Нүүрс-устөрөгчийг ашиглах, хадгалах, тээвэрлэх үед асарч, алдагдах нь гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулж болзошгүй юм.



- **Металл болон нүүрсний уурхай:** Нүүрс угаах, хүдэр баяжуулахад ус ихээр шаардагддаг нь орон нутгийн газрын доорх усны нөөцийг шавхагдахад хүргэж болзошгүй.
- **Металл болон нүүрсний уурхай:** Уурхайн хаягдал ба тогтоол усны цөөрөм дэх хүчиллэг хаягдал ус шүүрэх нь урт хугацаанд газрын доорх ус металл, хүчлээр бохирдох асуудалд хүргэж болзошгүй.
- **Зарим шороон ордын ил уурхай:** Энэ нь газрын доорх усны байгалийн урсгал, тархацыг хааж, зогсоодог тул тухайн бүс нутгийн газар доорх ус ашигладаг хүмүүст нөлөөлж болзошгүй.

Газрын доорх усыг хамгаалах ач холбогдлыг хэзээ ч багаар үнэлж болохгүй. Улаанбаатар хот дахь Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд газрын доорх усны хяналтийн асуудлаар мэргэшсэн боловсон хүчин байдаг бөгөөд энэ хүмүүс томоохон төслүүд явж буй сумдад очиж ажиллах боломжтой байх. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, БОАЖЯ хамтран Петрочайна XXI талбайд нүүрс-устөрөгчийн бохирдлын хэмжээг шалгах хяналтын цооногийн сүлжээг байгуулсан бөгөөд жилд хоёр удаа хэмжилт хийдэг. Үүнээс гадна газрын доорх усанд эрсдэл үүсч болзошгүй эмзэг газруудад орон нутгийн байцаагчид хяналт тавих арга замыг ойлгоход нь зориулан сумын түвшинд нэмэлт сургалт явуулах нь тустай байх нь дамжиггүй. Гэсэн хэдий ч өмнөх хэсэгт дурдсан амьдралын мөчлөг ба түүний нөлөөллийн талаарх хосолсон сургалтад хамрагдаж дүүргэсний дараа ийм сургалтад хамрагдах нь илүү үр дүнтэй байхаар байна.

Агаарын чанарын хяналт

Мэдээлэл цуглуулах нэлээд хэдэн уулзалтын үеэр оролцогчид уурхайн зам, талбайгаас үүдэлтэй тоосжилттой холбоотой агаарын чанарын асуудал, агаарын чанарыг хянахтай холбоотой чадавх бүрдүүлэх асуудлыг хөндөж байсан. Агаарын чанарыг сайжруулахын ач холбогдлыг явч орхигдуулж болохгүй. Гэвч БОАЖЯ-нд агаарын чанарыг шалгах явуулын тоног төхөөрөмж, мэргэшсэн мэргэжилтэн, туршлага байгаа бөгөөд томоохон төслүүд явагдаж буй сумдад тусалцаа үзүүлэх боломжтой гэж бодож байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар БОАЖЯ-тай хамтран Петрочайна XXI талбай дээр NOx, SOx, том ширхэглэгт тоосонцорын агууламж болон бусад элементийн үзүүлэлтэд хяналт тавьж, жилдээ хоёр удаа хэмжилт хийдэг.

Сумын оршин суугчид, малчдын бэлчээртэй ойролцоох тоосжилттой холбоотой агаар дахь тоосонцорын асуудлаар чадавх бүрдүүлж, орон нутгийн онцлогийг тусгасан сургалт явуулбал өгөөжтэй эсэх нь дараах хэдэн шалтгааны улмаас эргэлзээтэй байна. Үүнд:

- Сумын олон замаас үүссэн тоосжилт үе үе дэгдэж, богино хугацаагаар агаарыг бохирдуулдаг (замын ачаалал багатай). Тиймээс ихэнх дэгдсэн тоос нь гарсан газраасаа 100м-200м зайд эргэн буудаг.
- Салхинаас үүсэлтэй сул өнгөн хөрсний ширхэглэг агаарт хийсэх үзэгдэл тал нутагт агаарт шороо тоос дэгдээдэг нь бага анзаарагддаг ч, байнга явагдах магадлалтай.
- Сумын оршин суугчид нүүрс түлснээс гарч буй агаарын бохирдол нь үүнээс хамаагүй илүү аюултай бөгөөд жилийн ихэнх хугацаанд шороо тоосноос илүү их агаар дахь том ширхэглэгт тоосонцрын байнгын эх үүсвэр болдог байна.

Эдгээр толгой эргүүлсэн хүчин зүйлийн улмаас сумын ойролцоо агаар дахь том ширхэглэгт тоосонцрын хэмжээний хяналтын системийг байрлуулах юм бол зөвхөн нийт тоосонцрын хэмжээг л мэдэх боломжтой. Харин ялгаатай хүчин зүйлсээс үүдсэн бохирдлын хэмжээг нарийг зааглаж мэдэхэд хүндрэлтэй болгодог. Гэсэн ч хэрэв сум энэхүү хяналтын системийг хэрэгжүүлэхийг хүсвэл жил тойроод агаар дахь тоосонцрын хэмжээг бүртгэх зорилгоор суурилуулан ашиглаж болох харьцангуй хямд систем бий (PurpleAir цахим хуудас map.purpleair.org-г харна уу).

Лабораторийн хүрэлцээ

Одоогийн байдлаар сумын түвшинд лаборатори дутмаг байгаагаас болон байцаагч, байгаль хамгаалагч нарын хөрс болон усны бохирдлыг тодорхойлж, хянах боломж хязгаарлагдмал байна. Чойбалсан хот дахь лаборатори нь зөвхөн ус, хүнсний бүтээгдэхүүн доторх бактерийн бохирдлын шинжилгээг хийж байна. Өргөн тархсан органик, органик бус бодисын шинжилгээ хийх чадалтай, сайн тоноглолтой лаборатори зөвхөн Улаанбаатар хотод л байна. Энэ нь алслагдсан сумаас авсан дээжийг тээвэрлэх, чанарыг нь баталгаажуулахад бэрхшээл учруулж байна. Миний ойлгож байгаагаар яг одоогийн байдлаар МЕРИТ шинэ лабораторийн байгууламж барихад дэмжлэг үзүүлэх боломжгүй байна.



Номзүй

Д. Бямбажав. 2018 он. Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь орон нутгийн гэрээ: Төрийн манлайлал ба бодлогыг тодорхой болгох хэрэгцээ. Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн. 2018 оны 4 сарын 17

Ingen-Houzs, M. 2017 (a). *Олборлох салбарын Дорнодын эдийн засаг, төсөөт үзүүлж буй нөлөө*. МЕРИТ төсөлд зориулав. 2017 оны 6 дугаар сар.

Ingen-Houzs, M. 2017 (b). *Загвар гэрээний практик дахь байдал*. МЕРИТ төсөлд зориулав. 2017 оны 6 дугаар сар.

